

島田市



Shimada
City
Sightseeing
Guidebook

Шимада хот Аж үйлдвэр Аялал жуулчлалын газар Аялал жуулчлалын хэлтэс

427-8501 Шимада хот чюүо чёо 1-1 Утас: 0547-36-7163 факс: 0547-37-8200
URL <http://www.city.shimada.shizuoka.jp>

Шимада хот Аялал жуулчлалын холбоо

428-0047 Шимада хот Канаяа шинэ мачи 14-2 Утас: 0547-46-2844 Факс : 0547-46-2861
URL <http://www.city.shimada-ta.jp>



島

Shimada City Sightseeing Guidebook

モンゴル語版

歩

Оои гол болон Хуучин Токайдо хурдны замын дагуух аялал

хуудас 2
P.5

Оои гол гатлах нь Токайдо хурдны замын хамгийн хүнд даваа байсаар ирсэн. Голын хоёр талд байрлах хотууд нь шуудан хүргэлт бүхий өөр өөрийн өвөрмөц соёлтой боллоо хөгжсөн. Чулуугаар шигтгэсэн замтай гудамж, хуучны балгас, дэлхийн хамгийн урт модон гүүр зэрэг үзэх харах зүйлс ихтэй. Орон нутгийн хоол амтлахаа битгий мартаарай.

Шимада хотод зочлох газрууд 5

Оои голын дагуу байрлах Шимада хот бол жуулчдад санал болгох сэтгэл татам зүйлсээр баялаг хот юм. Хотын үзэсгэлэнт байгаль, найрсаг иргэд, Таны аялалыг дурсамж дүүрэн болгох болно. Энэхүү аялалын танилцуулгаар Шимада хотын үзвэл зохих 5 дурсгалт газрыг танилцуулж байна. Та аялалаа өөрийн хүссэн маршрутаар зохиож болохоос гадна Шимада, Канаяа, Каванэ хотоор тойрон аяласан ч болно. Бидний бэлтгэсэн танилцуулга Шимада хотод аялахад тань тус болно гэдэгт итгэлтэй байна.

Ногоон цайны урлагтай танилцах

хуудас 3
P.7

Шимада хот нь Японы ногоон цайны гол үйлдвэрлэгч бүсэд ордог. Макинохара хотын ногоон цайны тариалангийн үзэсгэлэнт газрыг үзэнгээ онцлог амт бүхий Шимада ногоон цай, Канаяа ногоон цай, Каванэ ногоон цай, түүгээр хийсэн амттан болон хоол зэргийг амтлаарай

хуудас 4
P.9

Уурын галт тэргээр аялах бяцхан аялал

Хуучныг санагдуулам уурын хөдөлгүүрт галт тэргээр аялангаа Ооигава төмөр замын дагуух уул даван долгиолон үргэлжилсэн ногоон цайны талбай, хаврын сакура цэцэгс, интоорын мод, эртний төмөр замын буудал зэргийг үзэх боломжтой.

Жилийн турш үзэх зүйлс ихтэй, аялахад тохиромжтой газар

Шимада хот улирал бүр өөр өөр, онцлог зүйлс ихтэй. Тухайлбал “Шимада Оби мацүри” / Кимоногийн бүсний баяр / Шимада Магэ мацүри / Үсний загварын баяр / Канаяа ногоон цайны баяр зэрэг Японы улирлын онцлогтой баяр наадмыг үзэж болохоос гадна уламжлалт ардын бүжиг болон улирал бүр өнгө гоёлоо солидог цэцэг, намрын солонгорсон навч бүхий үзэсгэлэнт байгалиар аялах боломжтой.

хуудас 1
P.3

Спорт тоглоомоор тоглож, халуун рашаанд алжаалаа тайлах

хуудас 5
P.11

Өдөр тутмын завгүй өдрүүдээ түр мартаж, цэвэр агаарт спорт тоглоомоор тоглон, байгалийн халуун рашаанд биеийн алжаалаа тайлаарай.



Каванэ сакура цэцгийн баяр Газрын зураг 1-1

Энэхүү баярыг сакура цэцгийн тунель болон Тэннозан, Рёокучи цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулдаг. 200 гаруй Сакура цэцгийн мод тарьсан тунель дундуур уурын галт тэргээр аялах бөгөөд энэ арга хэмжээ нь зураач, гэрэл зурагчдын сонирхлыг ихээр татдаг.

Зохион байгуулах сар

3 дугаар сарын сүүл, 4 дүгээр сарын эхэн

MAP 1-1

Сарнайт толгой Наадам Газрын зураг 1-2

Шимада хот нь сарнай цэцгийн хүрээлэнтэй. Сарнай цэцэг тарих сургалт, цэцгийн худалдаа, урлагийн тоглолт зэрэг төрөл бүрийн арга хэмжээ явагддаг.

Зохион байгуулах сар

5дугаар сар,10 дугаар сар

MAP 1-2



Каная ногоон цайны баяр

4 дүгээр сарын эхээр шинэ цайны навч нахиалах үеэр тэмдэглэдэг цай тариалагчдын баяр юм. Цайг билэгдсэн үндэсний хувцастай 1000 эмэгтэйн бүжиг сэтгэл татам бөгөөд үндэсний бөмбөрийн үзүүлбэр зэрэг бусад арга хэмжээ зохион байгуулагдагддаг. Анхны цай хураах улирлыг угтаж буй баяр юм.

Зохион байгуулах сар

4 дүгээр сарын эхээр (2жилд 1 удаа)



Шимада үсний загварын баяр

Торагозен бүсгүйн зохион бүтээсэн үсний загвараар 60 орчим эмэгтэй уламжлалт үсний загвар үзүүлэн бүжиглэж Утажи сүмд талархал илэрхийлэн залбирдаг.

Зохион байгуулах өдөр

9 дүгээр сарын 3 дугаар долоо хоногийн Ням гаригт.



Шимада хотын хамгийн том баяр - Оби наадам

1695 оноос уламжлагдаж ирсэн үндэсний баяр наадмын нэг болох Оби наадам нь 3 жилд нэг удаа болдог. Кашима бүжиг бүжиглэнгээ урт жагсаалаар явдаг бөгөөд хамгийн том үзүүлбэр нь үндэсний хувцастай 25 дайчин эрс оби бүсэнд 2 талдаа модон сэлэм зүүж бүжиглэдэг.

Зохион байгуулах өдөр

3 жилд нэг удаа 10 дугаар сарын дунд үеэд 3 хоног үргэлжилдэг.



Кашима бүжиг

XVII дугаар зууны сүүлд Шимада хотод тархсан тахал өвчинг үгүй болгохыг хүсэн залбирах зорилгоор Оои сүмийн орчимд Касуга хийдийг нээсэн түүхтэй бөгөөд энэхүү үйл явдлыг дүрслэн бүжиглэдэг баяр юм.

Зохион байгуулах өдөр

10 дугаар сарын дундуур
Оби мацури баярын үеэр болдог.



Жилийн туршид үзэх зүйлс ихтэй

Шимадагийн зөөлөн уур амьсгал нь бүтэн жилийн турш өнгө алагласан цэцэгсээр дүүрэн байх нөхцлийг бүрдүүлдэг. 2 дугаар сард чавганы цэцэгсээр эхэлж, сакура цэцэг, цээнэ цэцэг, шинэ цайны няхл навчис, сарнай цэцэгс ээлж дараалан дэлгэрч, үргэлжлэн намрын өнгө өнгийн навчсаар хучдаг. 1695 оноос хойш 3 жилд 1 удаа зохион байгуулагдаг Шимада Оби Мацури хэмээх үндэсний баяр нь өнгөрсөн үеийг Танд мэдрүүлнэ.

Жилийн турш цэцэгсээр дүүрэн

Шимада хотод улирал бүр олон янзын цэцэгс дэлгэрч бүтэн жилийн турш өнгө алаглан оршдог. Цэцэг цэцэгсийн эхэнд 2 дугаар сард чавганы цэцэгс дэлбээлж, дараа нь сакура цэцэг, сараана цэцэг, цээнэ цэцэг, доданцүцүжи хэмээх жижиг цагаан цэцэг, сарнай цэцэгс ээлж дараалан цэцэглэж, үргэлжлээд намрын өнгө өнгийн навчис угтдаг.



Катакүри (Макинохара цэцэрлэг)



Доданцүцүжи (Доданбара)



Токожи Хиеоши сүм дэх сармагчны бүжиг Газрын зураг 1-3

Сарумай хэмээх бүжгийг хоёр хүүхэд сармагчны баг өмсөн бүжиглэдэг үзүүлбэр юм.

Зохион байгуулах өдөр

4-р сарын хоёр дахь долоо
хоногийн Бямба гаригт

MAP 1-3



Номори Наадам Газрын зураг 1-4

Номори цөөрмийн дэргэд зохиогддог энэхүү баяр нь олон арга хэмжээгээр дүүрэн байдаг. Уламжлалт модон завиар уралдах, нууранд дэнлүү тавих, орой салют буудах зэрэг арга хэмжээ зохион байгуулагдаг. Нууранд тусах дэнгийн гэрэл, тэнгэрт цацрах салютын гэрлийн зохицоо нь гайхалтай дүр зургийг бий болгоно.

Зохион байгуулах өдөр

8 дугаар сарын 15

MAP 1-4

Оои голын эрэг дээрх салют буудлага Газрын зураг 1-5

Голын хоёр талаар төрөл бүрийн хэмжээ, өнгө, хэлбэр дүрс бүхий 8000 орчим салютын буудлага нь үзүүштэй зүйлийн нэг юм.

Зохион байгуулах өдөр

8 дугаар сарын 10

MAP 1-5

Чиманжи сүмд бут чөтгөрийг зайлуулах ёслол 1-6

Ирж буй шинэ жилд эрүүл энх байхыг хүсэн билэгдэж, баг өмссөн 3 хүн бут чөтгөрийг үлдэн хөөх ёслолыг хийдэг. Энэ заслыг хотын захирагч асан алдарт жанжин Минамото Ёритомо-гийн захирамжаар шинээр сэргээн босгосон танхимд үйлддэг.

Зохион байгуулах өдөр

1 дүгээр сарын 7-ны өдөр

MAP 1-6



Жилд зохиогдох арга хэмжээ

1 сарын 7: Чибэ уулын Чиманжи хийдэд бут чөтгөрийг зайлуулах ёслол
1 сарын эхээр: Сайн сайхан хувь заяаг билэгдсэн Долоон Бурханы баяр
1 сарын 17: Чибэ уулын Чиманжи хийд дэх үзэсгэлэн худалдаа
2 сарын 11: Шокакужи хийд Дайкүро одон баяр
2 сарын дундуур: Изама цэцэрлэгт хүрээлэнд чавганы цэцэг дэлгэрнэ.
2 сарын дундуур: Ита чавганы цэцэг ургах баяр
3 сарын дундуур: Кайкужи хийдийн цэцэрлэгт сакура дэлгэрнэ.
3 сарын сүүлээр: Ямамакэдэра загасны цөөрөм нээгдэнэ
3 сарын сүүлээр: Оцугани гол дагуу сакура дэлгэрнэ.
3 сарын сүүлээр: Макухара цэцэрлэг дотор сараана цэцгийн хүрээлэн нээгдэнэ
4 сарын сүүлээр: 4 сарын эхэн хүртэл: Каванэ сакура цэцгийн баяр
4 сарын эхээр: Каная ногоон цайны баяр ※2 жилд 1 удаа
4 сарын дундуур: Шинсүи цэцэрлэгт сакура цэцгийн баяр
4 сарын 2 дахь Бямба гариг: Токожи Хиеоши хийдэд сармагчны бүжиг
4 сарын дундуур: Хёкожи сүм дэх цээнэ дэлгэрнэ.
4 сарын дундуур: Чибэ ууланд доданцүцүжи цэцэглэнэ.
5 сарын эхэнд: Эйсэй Зэнжи цайны баяр
5 сарын дундуур: Харын сарнай цэцгийн баяр
5 сарын сүүлээр: Хорай гүүрэн дэх шавсан дэнлүүний баяр
6 сарын 1: Оои голын загас агнуурын хорио тавигдана
6 сарын дундуур: Сасама дүүрэгт гэрэлт цог хорхойны улирал эхлэнэ
6 сарын 30: Оои хийдэд хагас жилийн засал

Шимада хот нь Эдогийн үеэс (1603~1868) хөгжиж цэцэглэсэн хот байсан төдийгүй үеэс үед өвлөгдөн ирсэн уламжлалт олон баяр ёслолтой бөгөөд энэ нь байгаль орчинтойгоо нягт уялдаатай байдаг. Сар бүр зохион байгуулагдах дараах баяр ёслол байдаг.

7 сарын эхээр: Рокүго гудамж дагуу Кана цэцэг дэлгэрнэ
8 сарын эхээр: Шимада хотын зуны баяр
8 сарын 10: Оои голын эрэг дээр салютын буудлага болно
8 сарын 15: Киши үзэсгэлэн худалдаа
8 сарын 15: Номори наадам
8 сарын 26: Хигүри Жисо баяр
9 сарын 3 дахь 7 хоногийн Ням гариг: Шимада үндэсний үсний загварын баяр
10 сарын дундуур: Хашүкура осажки эмэгтэйнүүдийн бүжгийн баяр
10 сарын дундуур: Шимада хотын хамгийн том баяр болох Оби наадам (3 жилд 1 удаа Бар, Могой, Сармагчин, Гахай жилүүдэд 3 өдөр үргэлжилдэг)
10 сарын дундуур: Намрын сарнай цэцгийн баяр
10 сарын дундуур: Изама хачимаку сүмийн баяр
10 сарын сүүлээр: Сасама бурханы баяр
10 сарын сүүлээр: Хашүкура баяр
10 сарын сүүлээр: Шимада Оои голын гүйлт
11 сарын дундуур: Шимада хотын соёл, үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа
11 сарын эхээр: Сатояма урлагийн аялал
10 сарын сүүлээс 11 сарын дундуур: Каванэ хотын баяр
11 сарын дундуур: Шимада аж үйлдвэрийн баяр
11 сарын дундуур: Ваппазава Шинсүи цэцэрлэгийн намрын баяр
11 сарын дундуур: Чибэ уул доданцүцүжи модны намрын өнгө
12 сарын 16: Рокүго галын наадам



Ои голын эргээр аялах

Эрт дээр үеэс Оои гол дагуу хүмүүс амьдарсаар ирсэн. Эдогийн үед голын хоёр талд байрлах Шимада, Каная хотууд шуудан хүргэлтийн гол үүргийг гүйцэтгэж, хожим нь тэргүүлэх соёл бүхий хотууд болсон юм. Оои голын эргээр эртний уламжлалаа хадгалсан хуучин гудамж дундуур алхах нь өнгөрсөн үед очсон мэт санагдана.



Шимада хотын музей Газрын зураг 2-2

Музейн 1 давхарт Эдогийн үед Оои голоор хэрхэн гатлаж байсан тухай харуулдаг бол 2 давхарт тусгай үзэсгэлэн гардаг. Музейн өргөтгөл хэсэгт ихэвчлэн модон бараар урласан уран бүтээлийн үзэсгэлэн тавигддаг.

Холбогдох утас 0547-37-1000
Цагийн хуваарь 09:00~17:00 (Даваа гаригт болон Японы үндэсний баярын өдрийн дараагийн өдөр амарна)



Гиннесийн гэрчилгээ

Хорай гүүр Газрын зураг 2-1

Түүхэн киног санагдуулам Хорай гүүрийг 1879 онд Макүхари орчмын тариаланчид Хацүкүра болон Шимада хотыг холбох хөдөө аж ахуйн зориулалтаар барьсан. Одоо үед зөвхөн явган хүн, унадаг дугуйчид зугаалдаг ба Шимадад ирсэн жуулчдын очдог гол газруудын нэг болсон. 897,4 м урт, 2,4 м өргөн Хорай гүүр нь дэлхийн хамгийн урт модон гүүр хэмээн Гиннесийн номонд бичигдсэн юм. Гэрлээр чимэглэсэн Хорай гүүр үдшийн бүрэнхийд гайхалтай үзэсгэлэнтэй харагддаг.



Оои гол гатлах хотхон Газрын зураг 2-3

Эрт дээр үеийн Оои голыг гатлах үеийн байшин, голын усны түвшинг тогтоогч, голын зохион байгуулагч, гол гатуулагч зэрэг хуучин үеийн орчин ахуйтай танилцах



Хуучин Токайдогийн чулуугаар шигтгэсэн зам Газрын зураг 2-5

Каная, Кикүгава орчим нь уулархаг өгсүүр тул Эдогийн үед Токайдо-д аялагчдаас ихээхэн чадал шаарддаг байжээ. 1991 онд Канаягийн оршин суугчид 430 м урт замыг чулуугаар шигтгэн хийж тохижуулсан. Харин Кикүгава уулын 611 м урт хуучин замыг 2000 онд мужийн соёлын өвд бүртгэсэн. Энэхүү чулуун замыг хөрсний нуралтаас болно хальтаргаанаас хамгаалж анх барьсан.



Башёгийн шүлгийн чулуун хөшөө Газрын зураг 2-4

Эртний шүлэгч Мацүо Башё нь Токайдо орчмоор аялах үеэрээ байгалийн гоо үзэмжийг дүрсэлсэн олон алдартай шүлэг зохиосон. Түүний шүлгийн чулуун хөшөөг цэцэрлэгт хүрээлэнд байрлуулсан.



Мегүри кафе

Хуучин Токайдогийн Каная чулуугаар шигтгэсэн замын төгсгөлд байрлах энэхүү кафе ресторанд нутгийн амт бүхий хоол, амттан санал болгодог.

Холбоо барих 0547-45-5715
Цагийн хуваарь 9.00-17.00 (Даваа гаригт болон үндэсний баяраар амрана)



Сүвахара цайзын балгас Газрын зураг 2-6

Такеда Кацүёри аавынхаа ажлыг гүйцээх зорилгоор 1573 онд энэхүү цайзыг барьсан. Түүний аав Шинген цайзыг бариулах ажлыг эхлүүлж байсан. Цайзны үлдэгдэл балгас нь үндэсний соёлын өвд бүртгэлтэй.



Аялалын Сакэ иж бүрдэл

Энэхүү сакэ /Японы үндэсний архи / Оои голын усаар найруудан, Оби Мацүри наадмыг дүрслэн чимэглэсэн гар хийцийн уутанд хийсэн нь Шимадагийн бас нэг шинэ бэлэг болсон юм.

Холбогдох утас 0547-35-0018

Орон нутгийн хоол

Орон нутгийн амтат хоол нь Танд мартагдашгүй дурсамж үлдэнэ.

Амталсан будаа ба шарсан дүфү



Энэ хоол нь Эдогийн үеэс эхтэй бөгөөд ногоогоор амталсан будааг мисо амтлагчтай шарсан дүфүтэй идэхэд маш амттай.

Харихари шөл (зэрлэг гахайн махтай халуун тогоо)



Зэрлэг гахайн махыг нимгэн хэрчиж төрөл бүрийн ногоотой хамт чанасан халуун шөл.

Ямамамэ худл загас



Шарж эсвэл жигнэж болгосон худл загасыг амтлаж үзээрэй.

Нутгийн дарс



Оои голын тунгалаг усаар найруулсан "Ои Накасэ" "Вакагаса" "Ои короши" зэрэг сархад үйлдвэрлэдэг.



Ногоон цай амтлах



Ногоон цайны өнгө, амт, үнэр нь гайхалтай сайхан мэдрэмжийг төрүүлдэг. Шимада нь ногоон цайны гол үйлдвэрлэгч болохын хувьд цайны ногоон талбайг үзэж сонирхох, цай амтлах, ногоон цайгаар амтлан хийсэн амттан хоол зэргийг таван мэдрэхүйгээрээ мэдрэх боломжийг жуулчдад олгодог.



Макинохара цэцэрлэгт хүрээлэн Газрын зураг 3-2

MAP 3-2

Канаяа Шимада хотын өндөрлөгөөс Оои гол,Фүжи уул, Сүруга булан, Изү хойг, Өмнөд Альпс өргөн харагдац бүхий газар нутагтай. Макинохара паркт цайны урлагийн мастер Эйсai Зэнжигийн цайны ёслолд оруулсан хувь нэмрийг үнэлж, түүний хөшөөг нь байрлуулсан байдаг. 3 дугаар сарын сүүл 4 дүгээр сарын эхээр сараана цэцэг дэлгэрч өнгө үзэмж нэмдэг. Тус паркийн шөнийн харагдац нь “Японы үндэсний өв”-д бүртгэгдсэн байдаг.



Шимада, Канаяа, Каванэ хотын цай

Тус бүс нутагт Шимада, Канаяа, Каванэ гэсэн 3 төрлийн ногоон цайны бүстэй. Уулархаг хэсэгт тариалсан ногоон цай нь ердийн цайнд ордог бол Макинохара уулын цай нь илүү өтгөн байдаг. Тэдгээр нь өөр өөрийн онцлог амт, үнэртэй байдаг.Оои голын эрэгт тарьсан сайн чанарын цайг харьцуулан уухыг санал болгож байна.

Холбогдох утас 0547-36-7409

(Шимада хотын хөдөө аж ахуй, ойн газар)



Макинохара уулын ногоон цайны тариалан Газрын зураг 3-1

MAP 3-1

Оои голын баруун хэсэгт орших Макинохара ууланд асар том талбайд ногоон цайны тариалан бий. 1860 онд Самурайн засаг унасны дараа Токүгава болон түүний залгамжлагчид тус газрыг хамгийн том цайны тариалан болгожээ. Энэхүү тариалангийн талбайнаас Фүжи уул гайхалтай харагддаг тул Шизүока мужийн хамгийн үзэсгэлэнтэй газруудын нэгд тооцогддог.



Шимадагийн ногоон цайны төлөвлөгөө

Шимада хот нь өөрийн онцлог, дахин давтагдашгүй цайг сурталчлахын тулд 2015 онд өөрийн цайны логог бий болгосон. Энэхүү лого нь Шимадагийн цайг бренд болтол олон нийтэд таниулсан юм. Цаашид дотооддоо болон гадаадад үргэлжлүүлэн сурталчлах болно.



Ногоон цайны амттай хоол, хүнс


Мачяа цайны / Өтгөн ногоон цай / Амтанд тохирсон, ногоон цайгаараа хийсэн амттан болно хоолтой тавтай танилцана уу.

Ногоон цайгаар хийсэн амттан

Ногоон цайны таияки



Каванэ дайфүкү



Ногооны цайны ёкан



Шимадагын амттан



Команжю Курояако

Ногоон цайгаар хийсэн хоол



Ногоон цайгаар хийсэн сагад будааны гоймон.





Уурын галт тэргээр аялах бяцхан аялал

Каная хоттой Оои голын ойролцоох хотуудыг холбож өгдөг төмөр замаар өнөөг хүртэл уурын хөдөлгүүрт галт тэрэг явж байна. Уулын засвараар цуйрайтах галт тэргийн яндангийн дууг сонсонгоо голын дагуу аялж, унаган байгалийн үзэмж, халуун рашаанд орж алжааллаа тайлан аялахыг санал болгож байна.

Шинэ Каная төмөр замын буудалд зураг авалт хийсэн уран бүтээлүүд

- Ээктэйгээ амьдарвал (Кино)
- Ээжийн мод (Кино)
- Манжуурын улаан наран (Кино)
- Ванкуверийн өглөөний наран (Кино)
- Массан (Олон ангит цуврал кино)



Шинэ-Каная төмөр замын буудал Газрын зураг 4-1

Энэхүү төмөр замын буудалд олон ангит болон уран сайхны киноны зураг авалт их хийгддэг. Буудлын талбайд хуучин загварын галт тэрэг болно уурын хөдөлгүүрт галт тэрэг зогсож байгаа нь төмөр замын үзэсгэлэн мэт сэтгэлд дотно харагддаг.

Уурын галт тэргийн Тойрог зам

Оои голын төмөр замын Шинэ Каная буудлын хотхонд уурын хөдөлгүүрт галт тэргийн зүтгүүрийн чиглэлийг эргүүлж өөрчилдөг тавцан байдаг.Та уурын галт тэргийг хөдлөхөөс нь өмнө хархаас гадна, уурын галт тэрэг нь чиглэлээ урагш нь өөрчлөхийг үзэх боломжтой.

Хигири Жизо хөшөө Газрын зураг 4-2

Оои голын төмөр замын Хигири буудлаас 2 минутын зайд Жизо бурхны чулуун хөшөө бий. Хэдний өдөр, хэзээ хүртэл гэж залбирвал тэр гуйлт нь биеддэг гэсэн хуучны домог байдаг. Сар бүрийн 26-ны өдөр болно ,8 сарын 26нд өргөн хүрээтэй тэмдэглэдэг.



Бэлэг дурсгалын дэлгүүр Газрын зураг 4-1

Шинэ Каная төмөр замын буудлын өмнө байрлах дэлгүүрт уурын галт тэрэг болон орон нутгийн онцлог зүйлсийг харуулсан бэлэг дурсгалын зүйлс худалдааг. Дэлгүүрт 1955 аас 1965 оны хуучны галт тэргийн өртөө болон Каная хотын тоглоомон үзэсгэлэнг байрлуулсан.

Холбогдох утас 0547-45-4112
Цагийн хуваарь 9.00-17.00 цаг хүртэл ажиллана.

Номоригийн Икэ цөөрөм Газрын зураг 4-3

Оои гол чиглэлээ өөрчлөх үед бий болсон энэ цөөрөмд загас барихад тохиромжтой.Ойролцоо орших Номори парк нь байгалийн үзэсгэлэн бүрэлдсэн газар юм.



Иэяма сакура цэцгийн тунель Газрын зураг 4-4

Шизуока мужийн Каванэд сакура цэцэг үзэх хэд хэдэн алдартай газар бий. Хамгийн үзэсгэлэнтэй газар бол Иэяма сакура цэцгийн тунель. Хоёр талаар битүү цэцэглэсэн сакура цэцгийн аундуур уурын галт тэрэг явж өнгөрдөг алдартай газар юм.



Морь уналгын цэцэрлэгт хүрээлэн Газрын зураг 4-5

Номоригийн ойролцоо морь уналгын клуб байрладаг. Клубын сургагчид нь морь унахаар ирсэн хүмүүст морь унахыг заадаг ба морь унах хугацаа 30 минут байдаг. Энд зочид буудалд буудаллах боломжтой. Үнэ нь 3240 иен. Буудалд буух болон морь унахад урьдчилан захиалга өгөх шаардлагатай.

Холбогдох утас 0547-53-4079
Цагийн хуваарь 9.00-18.00 цаг хүртэл ажиллана.



Шимада хот Сансон Тоши Хамтын ажиллагааны Сасама төв Газрын зураг 4-6

Өмнө нь бага сургууль байсан үзэсгэлэнт уулын дунд байрлах энэ төвийг хүүхэд, залуучуудын сургалт хийх төв болгон засан тохижуулсан. Энд мөн соёлын болон спорт сургалтын хөтөлбөрүүд зохиогддог.

Холбогдох утас 0547-54-0661



Иэяма төмөр замын буудал дээр зураг авалт хийсэн кинонууд

- Цэцэгс (Кино)
- Ховордсон Яаматай улс (Кино)
- Төмөр замчин Поппояа (Кино)
- Жүнко кирари (Драм)
- Хадака но Тайшо Хороки гэх мэт (Драм)



Иэяма буудал Газрын зураг 4-7

Энэ хот нь эртнээс жуулчид олноор очдог газар байсан. Төмөр замын модон буудал нь хуучны хэв загвар бүхий хотын гудамжуудтай маш сайхан зохицдог бөгөөд киноны зураг авалт байнга хийгддэг газруудын нэг юм.



Төмөр замын дагуух зураг авалт хийдэг газруудад зочлоорой

- <http://www.shimada-cci.or.jp/fss/>
- Холбогдох утас: 0547-36-7163 Fax:0547-37-5250

Ооигава төмөр замаар уурын галт тэрэг үзэсгэлэнт газруудаар дайран өнгөрөхөөс гадна жижиг төмөр замын модон өртөө , уулын дундах жижиг хотууд, Оои голын дагуух гайхалтай байгалийн дүр зураг бүхий газруудаар аялдаг. Эдгээр киноны зураг авалт хийдэг газруудад очиж үзэн, дурсгалын зураг татуулаарай.



Жижигрүүлсэн төмөр зам

Шимада хотын төв цэцэрлэгт байрладаг жижигрүүлсэн галт тэрэгний зам. Уурын галт тэрэг болно хурданы галт тэрэг Н700-д суусан мэт сэтгэгдэл төрөх бэсрэг хувилбарт сууж, 5 минут аялаарай. Төмөр замын гүүрээр гарч, модон барилгуудыг үзэж сонирхох нь өндөр сэтгэгдэл төрүүлнэ.

Ажиллах өдөр : Бямба,Ням гариг ,Японы үндэсний баярын өдөр болно1 ба 2 дугаар сар, бороотой өдрүүдээс бусад өдөр ажиллана.
Цагийн хуваарь : 4-9 дүгээр сард 10:00-17.00
10-3 дугаар сард 10:00-16:00
Төлбөр : 100 иен (Бага сургуулийн сурагчдаас дээш)
Холбогдох утас : 0547-36-7163



Спорт тоглоомоор тоглож, халуун рашаанд алжаалаа тайлаарай

Ои голын эрэг дээр 17,9 км газрыг хамарсан марафон гүйлтийн талбай, гольфийн талбай, бейсбол, хөлбөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор байрладаг. Энэхүү цогцолборт хотын иргэд, спортоор хичээллэх дуртай хүмүүс цуглардаг. Хөлсөө гаргасаныхаа дараа хот доторх байгалийн халуун рашаанд алжаалаа тайлан амралтынхаа нэг өдрийг тухтай өнгөрүүлээрэй.



Каванэ халуун рашаан – Газрын зураг 5-1Фүрэай но Изүми

MAP 5-1

Уурын хөтөлгүүрт галт тэргийн дууг сонсонгоо задгай халуун рашаанд орж, Халуун усан бассейн,саун,массажаан банн зэрэг төрөл бүрийн байгалийн халуун рашаантай. Натри, хлорид бүхий халуун рашаан нь нуруу, хүзүү хөших, арьсны өвчнийг анагаахад тустай. Мөн амралтын өрөө,хоолны газраас гадна, жижиг гольфийн талбайтай. Дотроо халуун рашаантай зуны байр ч бий.

Холбогдох утас 0547-53-4330
Цагийн хуваарь 9.00-21.00 цаг хүртэл ажиллана.
Сар бүрийн эхний Мягмар гаригт амрана.



Фүрэай зуслангийн байшин



MAP 5-2

Итавари но юү Газрын зураг 5-2

Таширо Сато халуун рашаан нь дотор байрладаг бөгөөд хүний биеийн арьсыг зөөлөн сайхан болгодог.Гадна талд силкэн банн, нүүрс хүчлээр баяжуулсан банн,бүхий халуун рашаан бий. Үүнээс гадна захиалгын өрөөн дотроо саун,халуун рашаантай бүхий япон үндэсний хоёр амралтын өрөө бий.

Холбогдох утас 0547-33-1148
Даваа-Баасан гаригт 9:00-21:00
Бямба, Ням гаригт 8:00-21:00

Даваа гаригт амрана. Хэрэв Даваа гаригт баярын амралтын өдөр тохиовол дараагийн ажлын өдөр амрана. 1 дүгээр сарын 1-ний өдөр мөн амрана.



Каванэ халуун рашаантай зочид буудал Газрын зураг 5-1

MAP 5-1

2014 оны 7 дугаар сард нээгдсэн зочид буудал нь 165 хүртэл хүн хүлээн авах хүчин чадалтай, япон загварын 8 өрөө, европ загварын 38 өрөөтэй. Халуун рашаан бүхий нийтийн усан санд орж, задгай агаарт нүүрс хүчлээр баяжуулсан усанд ажлаалаа тайлах боломжтой. Өдрийн амрагчдыг мөн урьж байна.

Захиалга авах утасны дугаар 0547-53-4320



Спортын цогцолбор бүхий Шимада хот

Голын эрэг дагуу марафон гүйлтийн болон хөлбөмбөгийн, бейсболын талбай бүхий халуун рашаантай Шимада хотод ахлах сургууль, коллежийн оюутан сурагчид, хамтран ажилладаг спортын баг тамирчид дасгал сургуулиалтаа байнга хийдэг. 2010 оны 3 дугаар сард нээгдсэн олон төрөлт спортын төвд бялдаржуулах танхим, усан сан, тулааны урлаг болон нум сум харвааны сургалтын танхим бий.

Холбогдох утас Шимада хот Аялал жуулчлалын газар 0547-36-7399



Спортын нэгдсэн төв Розу Арина Газрын зураг 5-3

MAP 5-3

Энэхүү байгууламж нь иргэдийг спортоор хичээллэн эрүүл амьдрах, цаашилбал хөнгөн атлетикаар хичээллэн өөрийн чадварыг ахиулах нөхцөлийг бүрдүүлсэн спортын олон төрлийн тоноглолтой. Шилэн хананы цаанаас нарны туяа тусаж, дотор талыг гэрэл гэгээтэй болгохоос гадна дотор талд болж буй спортын үйл ажиллагааг гаднаас харах боломж олгодог. Энд харицан мэдээлэл солилцох тохиромжтой газар юм.

Холбогдох утас 0547-37-4539

Оои голын дагуух марафон талбай Газрын зураг 5-5

MAP 5-5

Японы анхны нэг чиглэлтэй марафон талбай бөгөөд 17,9 км урттай, 7 м өргөн зам юм. Оои гол, Макинохара уул зэрэг үзэгдэх орчин сайтай тул амралтын өдрүүдэд гүйх, алхахаар зорин ирэгсэд олон байдаг.

Холбогдох утас 0547-36-7223
Шимада хотын захиргааны спортын газар



Ооигава спортын байгууламж Газрын зураг 5-4

MAP 5-4

Оои голын эргийн дагуу гольф, хөнгөн атлетик, хөл бөмбөгийн болон бейсболын талбай бүхий олон төрлийн спортын байгууламж байрладаг. Энд бүх насны хүмүүсийг хүлээн авч байрлуулж, спортоор хичээллэх боломжийг олгодог.

Холбогдох утас 0547-36-7223
Шимада хотын захиргааны спортын газар



Хүүхдийн төв

Шимада төмөр замын зогсоолоос 3 минут алхах зайд "Обириа" барилгын 4 дүгээр давхарт бага насны хүүхэд тоглох төрөл бүрийн тоглоомтой төв байрладаг. Мөн хүүхэд хөхүүлэх, хүүхэд асрах төхөөрөмжөөр тоноглогдсон. Бага хэмжээний төлбөртэйгээр хүүхдийн төсөөлөн бодох чадварыг сайжруулах төрөл бүрийн тоглоомтой Борүнэ тоглоомын өрөө бий. Энд нярай болон мөлхөө хүүхдэд зориулсан тусгай хэсэг ч байдаг. Гар урлалын зүйлс хийх, хоол хийх зэрэг улирлын чанартай арга хэмжээ энд зохион байгуулагддаг. 2 ба 3 дугаар давхарт хотын номын сан бий.

Холбогдох утас 0547-34-3341
Цагийн хуваарь 10:00-19:00

(Даваа гариг бүр амрана. Мөн 12 дугаар сарын 29-ний өдрөөс 1 дүгээр сарын 3 хүртэл амрана. Сургуулийн сурагчдын амралтын үеэр болон нийтийн баярын өдөр Даваа гариг тохиовол ажиллана.)
※Тоглоомын өрөө 17:00 цаг хүртэл ажиллах бөгөөд Борүнэ тоглоомоор тоглох цагийн хуваарь нэг удаа 2цаг.



Шимада хотын газрын зураг

Shimada City Map



Мэдээлэл

Хонох газар Зочид буудлуудын нэрс

Сэрэктон буудал Шимада буудлын урд	Утас: 0547-35-6700
Ракү—нэ Шимада	Утас: 0547-340-011
Рүтоин зочид буудал Шимада буудлын урд	Утас: 0547-37-0055
Ван буудал 1·2·3 Шимада	Утас: 0547-34-0123
Каппо Рёкан Кикүмото	Утас: 0547-35-2760
Яаматояа рёкан	Утас: 0547-36-5147
Каппо Рёкан Санпотэй	Утас: 0547-37-2032
Зочид буудал Рүтоин Шимада	Утас: 0547-38-3011
Ешида орох зам	
Кандэо зочид буудал Шизуока Шимада	Утас: 0547-30-5880
Шимада хот Яагай Кацудо төв уулын гэр	Утас: 0547-39-0736
Пэншён додан	Утас: 0547-35-1107
Буудал Масудая	Утас: 0547-38-0014
Гэтаяа рёкан	Утас: 0547-38-0279
Каппо рёкан үиочичи	Утас: 0547-37-3263
Каванэ онсэн буудал	Утас: 0547-53-4320
Сугитаяа рёкан	Утас: 0547-53-2205
Морияа рёкан	Утас: 0547-53-2062
Каванэ фүрэаи зуслангын байшин	Утас: 0547-53-4110
Азумааяа	Утас: 0547-53-2206
Каванэ нанамаяри-жюкү	Утас: 0547-53-2113
Сансон- Тоши корюү төв Сасама	Утас: 0547-54-0661
Минжюкү Фүи	Утас: 0547-54-0013
Сайхан морьдын цэцэрлэг	Утас: 0547-53-4079
Хөдөө аж ахуйн орон сууц [Рогү, Мисора]	Утас: 090-2575-1961
Хөдөө аж ахуйн орон сууц [Ицүка]	Утас: 080-6948-2171

Автобус

Шизүтэцү явсаацу шугам	Утас: 0547-37-2214
Дайтэцү аялалын автобус	Утас: 0547-46-2370

Төмөр зам

Оикава төмөр зам	Утас: 0547-45-4112
------------------	--------------------

Такси

Шимада такси	Утас: 0547-37-2101
Хэива такси	Утас: 0547-36-1000
Тоокай такси	Утас: 0547-38-3344
Оои такси	Утас: 0547-45-3131
Канаяа такси	Утас: 0547-45-2151
Дайдэцү такси	Утас: 0547-45-2121

Машин, Дугуй түрээслэх

Шимада машин түрээслэх газар	Утас: 0547-36-6565
Тоёода машин түрээслэх газар	Утас: 0547-36-1797
Шимада буудлын урдах дугуй түрээслэх	Утас: 0547-36-5100
НРО Хот төлөвлөлтийн Каванэ холбоо	Утас: 0547-53-3511
Дугуй түрээслэх	